

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ**

2021 он

АГУУЛГА

Нэг. Ерөнхий зүйл	1
Хоёр. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон байдал, үндэслэл	1
Гурав. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгийг сонгосон байдал	3
Дөрөв. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн байдал	4
4.1 “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:	4
а. “Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмалын эрэл, хайгуулын үйл ажиллагааг эрчимжүүлэх”	5
б.Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, тогтвортой хөгжлийг хангах	7
4.2 “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:	10
4.3 “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:	18
Тав. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх	23

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж
АМтХ	Ашигт малтмалын тухай хууль /2006/
АМГТГ	Ашигт малтмал газрын тосны газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ЗГ	Засгийн газар
ЗД	Засаг дарга
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ТЗЭ	Тусгай зөвшөөрөл эзэмшигч
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зүйл, заалтад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцох, давхардал, хийдэл, зөрчил байгаа эсэхийг тогтоох, арилгах, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад тус үнэлгээний ажлын зорилго оршино.

Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх тооцох аргачлал”¹-д заасны дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ үндсэн 5 шалгуур үзүүлэлтийн хүрээнд тэдгээрийг шалгах хэрэгслийг ашиглан хуулийн төслийн зохицуулалт нь уг хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлага, хуулийн төслийн зорилгод нийцсэн эсэх, зорилгод хүрэх боломжтой байдлаар тусгагдсан эсэх, хуулийн төсөл нь ойлгомжтой, зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр хууль тогтоомжтой нийцсэн эсэхийг үнэлж, төсвөөс гарах зардлын тооцоог хийж, тэдгээрийн үр дүнд үндэслэн анхаарах, өөрчлөх шаардлагатай зохицуулалтын талаар хуулийн төсөл боловсруулагчид зөвлөмж өгсөн.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал
4. Харилцан уялдаа
5. Зардал

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зорилго нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл шаардлагад нийцсэн эсэх, хуулийн төслийн үндсэн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмалын эрэл, хайгуулын үйл ажиллагааг

¹Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан.

эрчимжүүлэх, хариуцлагатай үүл үрхайг хөгжүүлэх, тогтвортой хөгжлийг хангах, геологи, үүл уурхайн салбарын тогтолцоог бэжжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах болгоход чиглэж буйг анхаарч, хуулийн төслийн зохицуулалт, арга хэмжээ нь хуулийн төслийн зорилгод хүрэх боломжтой байна уу гэдгийг үнэллээ.

“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг, тухайлбал, хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц зэрэг) байгаа эсэхийг шалгаж тооцов.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэх, хуулийн төсөл, түүний зохицуулалтыг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх боломжтой эсэхийг шалгах үүднээс холбогдох этгээдээс санал авах, хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийжээр сонголоо.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалт иргэд, байгууллагад хэрхэн нөлөөлөх, түүнийг эдгээр этгээдүүд (хуулийн төсөл шууд нөлөөлөх иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх эсэхийг шалгана. Өөрөөр хэлбэл, тухайн зохицуулалтаар иргэдийн эрх чөлөөг хязгаарлаж байгаа эсэх, аж ахуйн нэгжүүдэд шинээр үүрэг хүлээлгэсэн эсэх, эсхүл тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд нийцэх эсэхийг шалгана.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь Монгол улсын Үндсэн хууль, Монгол улсын Олон улсын гэрээ, холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг “Хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д заасан асуултад хариулах байдлаар үр нөлөөний үнэлгээг хийжээр сонгов.

“Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон улсын төсөвт ачаалал, хөнгөлөлтийг үүсгэх, төрийн байгууллагад хуулийн төслийг хэрэгжүүлэхэд үүсэх зардал, уг зардлын улмаас үүсэх үр дагавар зэргийг холбогдох аргачлалын хүрээнд тооцон судлав.

Ашигт малтмалын тухай хуулийн зохицуулах харилцаа нь иргэд олон нийтээс ихээхэн шүүмжлэл дагуулдаг, шүүхийн маргаан их гардаг, улс төрийн нөлөө их салбар учир хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтын хүрээнд хамрагдах этгээд /иргэн, хуулийн этгээд/ хүлээн зөвшөөрөх эсэхийг тодруулах зорилт бүхий “хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн болно.

Хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоог тусгайлан хийх тул цаг хугацаа, нөөцийн хэмнэлт хийх үүднээс “зардал тооцох” шалгуур үзүүлэлтийг Хавсралт Тайланд тусгасан болно.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ СОНГОСОН БАЙДАЛ

“Зорилгод хүрэх байдал”

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлага, хуулийн төслийн зорилгод хуулийн төслийн зохицуулалт нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, хуулийн төслийн зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авав.

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн зорилгыг хангахад чиглэсэн эсэхийг үнэлэхүүднээс хуулийн төслийн зорилгод хүрэхэд чиглэсэн хуулийн төслийн 83, 28, 88, 50, 51, 66, 67, 68, 73-р зүйлүүдийг тус тус сонгон авсан болно.

“Практикт хэрэгжих боломж”

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь практикт хэрэгжих боломж байгаа эсэхийг үнэлэхүүднээс хуулийн төслөөр шинээр бий болгож байгаа чиг үүрэг, эрх хэмжээ, бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой Хуулийн төслийн 18 дугаар зүйл, 16.1.3, 16.1.4, 16.1.7, 16.1.8, 16.1.9 дугаар заалтуудыг тус тус үнэлгээ хийхээр сонгосон болно.

“Ойлгомжтой байдал”

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэгт болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа. /Хуулийн төсөл 97 зүйлтэй/

“Харилцан уялдаа”

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа. /Хуулийн төсөл 97 зүйлтэй/

ДӨРӨВ. УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон бөгөөд урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон аргачлалд тодорхойлогдсон дараах шалгах хэрэгслүүд байна.

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 1, 18, 19, 20-р зүйл, 14.1.3-14.1.6, 80.2.6, 80.2.8, 81.2.7, 81.2.9, 81.2.6 дах заалт 12.1-12.4, 7.1 дэх хэсгүүд	Хуулийн төслийн дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.
2	Практикт хэрэгжих боломж	Төслийн 83, 28, 88, 50, 51, 66, 67, 68, 73-р зүйлүүд	Хуулийн төслийг тусгай зөвшөөрөл эзэмшигч, төрийн байгууллага, төрийн бус байгууллагуудад этгээдүүдтэй нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах, хуулийн төсөлд ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийх.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах
5	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Дээрх шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

4.1 “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Зорилгод хүрэх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс сонгосон хэм хэмжээг тухайн хуулийн төслийн зорилтыг хангахад чиглэгдсэн эсэхийг судлах замаар үнэлгээг тогтооно. Хуулийн төслийн зорилгыг дараах байдлаар тодорхойлсон байна.

1.1.Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмалын эрэл, хайгуулын үйл ажиллагааг эрчимжүүлэх, ашиглах, баяжуулах болон хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, тогтвортой хөгжлийг хангах, геологи, уул уурхайн салбарын тогтолцоог бэхжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Хуулийн төслийн зорилгыг агуулгын хувьд дараах 3 хэсэгт авч үзлээ.

А. “Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмалын эрэл, хайгуулын үйл ажиллагааг эрчимжүүлэх”

Энэ зорилтыг хэрэгжүүлэх зохицуулалтууд хуулийн төслийн 10, 13 дугаар зүйлүүдэд тусгагдсан байна.

9 дүгээр зүйл. Ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон газар

9.1.Ашигт малтмалыг хайх, ашиглах болон бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг дараах газарт явуулахыг хориглоно:

- 9.1.1. тариалангийн газар;
- 9.1.2. хот, тосгон, бусад суурин, нийслэл хотын эдэлбэр газар;
- 9.1.3. усны сан бүхий газар;
- 9.1.4. улсын тусгай хамгаалалттай газар;
- 9.1.5. улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар;
- 9.1.6. шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай;
- 9.1.7. аймаг дундын отрын бэлчээр;
- 9.1.8. улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай;
- 9.1.9. цөмийн төхөөрөмж барих, ашиглах зориулалтаар олгосон газар;
- 9.1.10. аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар;
- 9.1.11. гол, мөрний урсац бүрэлдэх эх.

9.2. Энэ хуулийн 9.1.11-д заасан хориглосон газрын хилийн заагийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

9.3. Энэ хуулийн 9.1-д заасан хориглосон газарт хамруулах тухай шийдвэр гаргасан байгууллага нь шийдвэр гаргаснаас хойш ажлын 10 хоногийн дотор ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад шийдвэрийн хувийг хүргүүлнэ.

10 дугаар зүйл. Ашигт малтмалыг хайх, ашиглахыг хязгаарласан газар

10.1. Ашигт малтмалыг хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагааг дараах газарт хязгаартай явуулж болно:

- 10.1.1. зам, шугам сүлжээний газар;
- 10.1.2. ойн сан бүхий газар;
- 10.1.3. улсын хилийн зурвас газар;
- 10.1.4. усны сан бүхий газрын хамгаалалтын бүс;

10.2. Энэ хуулийн 10.1-т заасан хязгаарласан газрын мэдээллийг холбогдох байгууллага нь ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад шийдвэрийн хувийг жил бүр шинэчлэн хүргүүлж, бүртгүүлнэ.

10.3. Энэ хуулийн 10.1-д заасан газарт хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагаа явуулахдаа тухайн хязгаарласан газрын хуулиар зөвшөөрсөн хэм хэмжээг мөрдөж ажиллана.

11 дүгээр зүйл. Хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн нөхөх олговор олгох

11.1. Энэ хуулийн 9.1.4, 9.1.5, 9.1.9-т заасан зориулалтаар Улсын Их Хурал хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон газрыг улсын тусгай хэрэгцээнд нөхөх олговортойгоор авч болно.

11.2. Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газар хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон газрыг улсын тусгай хэрэгцээнд нөхөх олговортойгоор авч болно.

11.3. Энэ хуулийн 11.1, 11.2-д заасны дагуу газрыг улсын тусгай хэрэгцээнд авах бол Засгийн газар

тусгай зөвшөөрөл эзэмшигчид мөн хуулийн 11.4-т заасан нөхөх олговрыг 90 хоногийн дотор олгоно.

11.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигчид олгох нөхөх олговрын хэмжээг дараах байдлаар тогтооно:

11.4.1.хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчид олгох нөхөх олговрыг хайгуулын ажлын тайланд туссан зардлыг үндэслэж тооцно;

11.4.2.ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид олгох нөхөх олговрыг хайгуулын ажлын тайланд туссан зардал болон ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээнд үндэслэж тооцно.

11.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөх олговрыг бүрэн төлснөөр тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд болон хэсэгчлэн буцаан өгнө.

11.6.Нөхөх олговрыг бүрэн төлөөгүй бол тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах эрхтэй.

Хуулийн төсөлд АМТХ-д тусгагдсан талбайг нөөцөд авах зохицуулалтыг хасаж хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайгаас зөвхөн 9.1.4, 9.1.5, 9.1.9-д заасан газрыг Улсын Их Хурал, үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газар улсын тусгай хэрэгцээнд авахаар заасан байна. АМТХ-д эрх бүхий байгууллага гэж өргөн хүрээгээр тодорхойлсон буюу орон нутаг тусгай хэрэгцээнд авч улмаар ашигт малтмал хайх, ашиглах үйл ажиллагааг тодорхойгүй үндэслэлээр хориглож, хязгаарлаж байсныг байсныг хасаж зөвхөн Засгийн газар шийдвэр гаргах, мөн зөвхөн улсын тусгай хэрэгцээнд авах гэж хүрээг хязгаарласан, 11.5-д зааснаар нөхөн олговрыг бүрэн төлснөөр ТЗЭ-ч нь уг тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд болон хэсэгчлэн буцаан өгөхөөр заасан нь ТЗЭ-чийн үйл ажиллагааг дэмжсэн хуулийн төслийн 1.1-д заасан Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмалын эрэл, хайгуулын үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилтод хүрэх зохицуулалт болсон байна.

18 дугаар зүйл.Ашигт малтмалын эрлийн үйл ажиллагаа

18.1.Энэ хуулийн 4.1.3-т заасан ажлыг улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж болно.

18.2.Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй эрлийн үйл ажиллагаанд энэ хуулийн 17.1.1-д заасан журмыг баримтална.

18.3.Эрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүйгээр гүйцэтгэнэ.

19 дүгээр зүйл.Эрлийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага

19.1.Эрлийн үйл ажиллагаа дараах шаардлагыг хангасан байна:

19.1.1.талбайн геологийн тогтцыг нягтлан, ашигт малтмалын хэтийн төлөвийг тогтоох;

19.1.2.ашигт малтмал байж болох хэсгүүд, хүдэр хянагч болон агуулагч структур, бүс, ашигт малтмалын эрдэсжсэн цэг, илрэл, геофизикийн, геохимийн, геоботаникийн шинж тэмдэг, гидрогеологи, инженер геологи, геоэкологийн нөхцөл зэргийг судлах;

19.1.3.геомэдээллийн санг нэгдсэн байдлаар бүрдүүлэх, баяжуулах, боловсруулах;

19.1.4.ашигт малтмалын эрдэсжсэн цэг, илрэлүүдийг үнэлэх, хэтийн төлөвийн зэрэглэлээр ангилах, дараагийн үе шатны ажил явуулах талбайг тодорхойлох.

19.2.Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг хүлээн авах журмыг Газрын хэвлийн тухай хуулийн 22, 23, 24 дүгээр зүйл, энэ хуулийн шаардлагад нийцүүлэн геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

19.3.Энэ хуулийн 4.1.3-т заасан ажлыг мөн хуулийн 9, 10 дугаар зүйлд заасан хориглосон, хязгаарласан газарт гүйцэтгэж болно.

20 дугаар зүйл.Эрлийн ажлын санхүүжилт, төлбөр

20.1.Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх эрлийн үйл ажиллагааны санхүүжилт тухайн судалгааг бүрэн

гүйцэтгэхэд өмнөх оны санхүүжилтээс багагүй байна.

20.2.Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх эрлийн ажлын явцад газар ашигласны болон бусад төлбөр төлөхгүй.

Эрлийн ажилд тавигдах шаардлага, эрлийн ажлын санхүүжилт, төлбөрийн тухай зохицуулалтыг төсөлд шинээр тусгасан ба хуулийн төслийн 17.1-д эрлийн ажлыг улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэхээр заасан байна. Мөн төслийн 19.2-т улсын төсөвт хуваарилсан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 30 хүртэлх хувийг геологи, уул уурхайн салбарын санхүүжилтэд хуваарилахаар шинээр нэмсэн нь хуулийн төслийн 1.1-д заасан Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмалын эрэл, хайгуулын үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилтод хүрэх зохицуулалт болсон байна.

14 дүгээр зүйл.Засгийн газрын бүрэн эрх

14.1.Ашигт малтмалын асуудлаар Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.1.3.хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицол батлах;

14.1.4.бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талбайн солбицол батлах;

14.1.6.энэ хуулийн 3.3-т заасан томоохон төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиглах талбайн солбицлыг батлах;

80 дугаар зүйл.Геологийн судалгааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

80.2.6.улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдсэн геологийн суурь судалгааны мэдээлэл, эрдэс баялаг, ашигт малтмалын хэтийн төлөвт үндэслэн эрлийн үйл ажиллагаа явуулах талбайн солбицлыг жил бүр тодорхойлох;

80.2.8.ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын болон өргөдлийн талбайн геологийн суурь судалгааны мэдээллийг бэлтгэх, талбай ялгах үндэслэл тодорхойлох;

81 дүгээр зүйл.Ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

81.2.7.энэ хуулийн 80.2.8-д заасан мэдээлэлд тулгуурлан тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын болон өргөдлийн талбайг ялгаж бэлтгэх;

81.2.9.бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талбайн солбицлыг тодорхойлж, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

81.2.6.энэ хуулийн 14.1.3, 14.1.4, 14.1.6-д заасан талбайн солбицлыг орон нутагт мэдэгдэх.

Засгийн газар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицол, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талбайн солбицол, энэ хуулийн төслийн 3.3-т заасан томоохон төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиглах талбайн солбицлыг батлахаар тус төслийн 14.1-д заасан байна. 2006 оны АМТХ-ийн 17.1, 17.2-т заасны дагуу АМГТГ тухайн талбай байрших сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг авч, 45 хоногийн дотор хариу өгөх процесс хасагдаж зөвхөн талбайн солбицлыг орон нутагт мэдэгдэх зохицуулалт тусгагдсан. Энэ нь тусгай зөвшөөрөл олгох үе шатанд аймгийн Засаг даргаас ирүүлсэн татгалзах санал нь хууль зүйн хувьд үндэслэлгүй болохыг тогтоолгохтой холбоотой маргаан ихээр гарч тусгай зөвшөөрлийг цуцлах нэг үндэслэл болдог байдлыг халах зорилгоор оруулсан зохицуулалт байх тул Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмалын эрэл, хайгуулын үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгод нийцсэн байна.

Б.хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, тогтвортой хөгжлийг хангах

12 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах ерөнхий шаардлага

12.1.Хайгуулын тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, мэргэжлийн хүний нөөцтэй, татвар төлөгч хуулийн этгээдэд энэ хуульд заасан журмын дагуу олгоно.

12.2.Ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 12.1-д зааснаас гадна санхүүгийн баталгааны гэрчилгээтэй байна.

12.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байх хугацаанд энэ хуулийн 12.1, 12.2-т заасан шаардлагыг хангасан байна.

12.4.Нэг тусгай зөвшөөрлийг зөвхөн нэг хуулийн этгээдэд олгоно.

Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад татвар төлөгч хуулийн этгээдэд олгоно гэсэн ерөнхий шаардлага 2006 оны хуульд тусгагдсан. АМТХ-д тусгагдсан “Монгол Улсад татвар төлөгч байх” гэсэн энэхүү хэлбэрийн шаардлага нь тусгай зөвшөөрөл хүсэгчийн хувьд эрх олгож байгаа зохицуулалт боловч нөгөө талаасаа нийгэм, эдийн засаг, эрх зүйн хүрээнд сөрөг үр дагавар үүсэх шалтгаан болсон байна. Учир нь 2004 он гэхэд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн тоо 7,000 давсан бөгөөд монгол орны нийт нутаг дэвсгэрийн 47 хувийг хамарч, хууль бус ашигт малтмал олборлох үйл ажиллагаа, уул уурхайн улмаас эвдэгдсэн, нөхөн сэргээлт хийгээгүй талбайн хэмжээ үлэмж өсөж, гол мөрний сав газар дагасан олборлолт хяналтаас гарсан. Дээрх байдлаас үүдэн 2010 онд байгаль орчныг хамгаалах нэр бүхий 600 гаруй төрийн бус байгууллагын шахалт, шаардлага болон “лицензийн хяналтгүй наймаа”-г таслан зогсоох гэсэн үндэслэлээр хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг хориглох тухай зарлиг гаргасан. Улмаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохыг хориглох тухай хуулийг баталж, хоёр удаа сунгасны эцэст ашигт малтмалын тухай хуулийг шинэчлэн баталж, дагаж мөрдөх хүртэл дахин хориглосон.²

Дээр дурдсанаар тусгай зөвшөөрөл олгохыг олон удаа зогсоосон нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тоо буурах гол шалтгаан болсон бөгөөд үүний үр дагаварт хайгуулын үйл ажиллагаа зогсонги байдалд орсон. Зохих мэргэжлийн, санхүү, техник, технологийн шаардлага, шалгуур байхгүй тохиолдолд тусгай зөвшөөрлөөр олгосон үйл ажиллагаа эрхлэх сонирхолгүй, зөвхөн дамжуулан худалдах зэрэг бусад зорилгоор тусгай зөвшөөрөл эзэмших үзэгдэл гарах болсон. Өөрөөр хэлбэл мэргэжлийн, санхүү, техник, технологийн шаардлага, шалгуур байхгүй тохиолдолд тусгай зөвшөөрлөөр олгосон үйл ажиллагаа эрхлэх сонирхолгүй, зөвхөн дамжуулан худалдах зэрэг бусад зорилгоор тусгай зөвшөөрөл эзэмшин, “татвар” хураагч болж хувирах үзэгдэл түгээмэл болсон байна.

"Хариуцлагатай тусгай зөвшөөрөл эзэмшигч" гэдэг нь уул уурхайн үйл ажиллагаа явагдах орон нутгийн иргэдийн эрх ашгийг хүндэтгэх, байгаль орчинд хохирол, нөлөө багатай үйл ажиллагаа эрхлэх, нөхөн сэргээлт-хаалтын ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх, цаг тухайдаа бүрэн хэмжээгээр ашигт малтмалын нөөцийн төлбөр болон холбогдох бусад татвараа төлөх гэсэн ухагдахуун байдаг.

Иймд хайгуулын болон ашиглалтын ТЗЭ-чид тавигдах шаардлагыг нэмэгдүүлэх нь хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, тогтвортой хөгжлийг хангах зорилгод нийцэж байна.

7 дугаар зүйл.Тусгай зөвшөөрлийн төрөл

² <https://www.legalinfo.mn/law/details/68?lawid=68>

7.1.Ашигт малтмалыг энэ хуульд заасан тусгай зөвшөөрлөөр баталгаажсан эрхийн хүрээнд хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагаа эрхлэх бөгөөд тусгай зөвшөөрөл нь дараах төрөлтэй байна:

7.1.1.ашигт малтмал хайх;


7.1.2.ашигт малтмал ашиглах;

7.1.3.ашигт малтмал баяжуулах.

2006 онд батлагдсан АМТХ-ийн дагуу ашигт малтмал хайх, ашиглах гэсэн тусгай зөвшөөрөл олгож байна. 2021 оны 12 дугаар сарын байдлаар Ашигт малтмал, газрын тосны газарт 135-н баяжуулах үйлдвэр бүртгэлтэй байна. Баяжуулах үйлдвэрүүдийн 38% нь буюу 49 үйлдвэр ямар нэгэн тусгай зөвшөөрөлгүй байна. Тусгай зөвшөөрөлгүй баяжуулах үйлдвэрийн хувьд төмөр-16, хайлуур жонш-14, алт-8, зэсийн 1, нүүрсний 12 баяжуулах үйлдвэр байна. АМТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д "ашигт малтмал ашиглах" гэж газрын гадаргуу, түүний хэвлий, хүдрийн овоолго, хаягдал, байгалийн уснаас ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, **баяжуулах**, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг хэлнэ гэж заасан боловч ашиглалтын тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын баяжуулах үйл ажиллагаа явуулж байгаа нь эдгээр аж ахуйн нэгжүүдэд хуульд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх үүргийг хэрэгжүүлэх талаар шаардлага тавих боломжгүйгээс гадна хуульд заасан арга хэмжээг тооцох хуулийн зохицуулалт байхгүй байна. 2015-2020 оны хооронд хайлуур жоншны бүтээгдэхүүнээс АМНАТ-ийн хэлбэрээр улсын төсөвт 103.1 тэрбум төгрөг төвлөрөх байснаас 21.8 тэрбум төгрөг буюу 21 хувь нь төвлөрчээ.



Үйл ажиллагаа явуулж байгаа баяжуулах үйлдвэрүүдийн хувьд баяжуулалтын үндсэн 5-н аргыг ашиглаж байна. Төмөр, манганы хүдрийн соронзон шинж чанарыг ашиглаж нойтон болон хуурай орчинд соронзонгоор ангилж байна.



Үйл ажиллагаа явуулж байгаа баяжуулах үйлдвэрүүдийн бараг тал хувь нь химийн бодис хэрэглэж байгаа нь үйл ажиллагаанд зайлшгүй хяналт зохицуулалт шаардлагатай болохыг харуулж байна.

Ашигт малтмалын баяжуулалтын тусгай зөвшөөрөл олгосноор дээр дурдсан хуулийн хийдлийг арилгаж, баяжуулалтын үйл ажиллагаа эрхлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавих боломж бүрдэж, татварын

орлогыг бүрэн төвлөрүүлэх боломж бүрдэнэ. Иймд үнэлгээ хийхээр сонгож авсан зохицуулалтын хувьд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагад нийцэж, хуулийн төслийн хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх зорилтыг хангах боломжтой байна.

4.2 “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хуулийн төслийн зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэхийг үнэлэхээр хуулийн төслөөс сонгож авсан дараах зохицуулалтын талаар туршсан байдалд дүн шинжилгээ хийх, санал авч дүгнэлт гаргах замаар үр нөлөөг судаллаа.

Төслийн Төслийн 83, 28, 88, 50, 51, 66, 67, 68, 73 дугаар зүйлд заасан зохицуулалтуудыг “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр шалган бодит байдалд хэрэгжих боломжтой эсэхийг үнэллээ.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд 2022 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс ... дугаар сарын ...-ны өдрийг хүртэл улс орон даяар нийт ... иргэд, салбарын хуулийн этгээд, судлаачдын дунд хэлэлцүүлэг хийж нийт гаруй санал, хүсэлт хүлээн авсан. Энэхүү санал хүсэлтийг нэгтгэн судалж, хуулийн төслийг эцэслэн боловсруулснаар практикт хэрэгжих боломж бүрдэнэ.

83 дугаар зүйл. Аймаг, нийслэл дэх геологи, уул уурхайн асуудал хариуцсан нэгж

83.1. Ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын харьяанд аймаг, нийслэл дэх геологи, уул уурхайн асуудал хариуцсан нэгж нь геологи, уул уурхайн салбарын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутагт хангах, сурталчлан таниулах, хөрөнгө оруулагч, тусгай зөвшөөрөл эзэмшигч, иргэдэд үйлчлэх, төрийн болон орон нутгийн төрийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

83.2. Аймаг, нийслэл дэх геологи, уул уурхайн асуудал хариуцсан нэгжийн даргыг геологи, уул уурхайн салбарт 5-аас доошгүй жил ажилласан, төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулж, аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөж ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага томилно.

АМГТГ, МХЕГ, БОАЖЯ-ны чиг үүргийн давхардал их, хоорондын харилцан уялдаатай, мэдээллээр түргэн шуурхай хангах асуудал дутагдалтай, нэгэнт чиг үүргийн давхардал байгаа тул хариуцлага хүлээх асуудал төвөгтэй, орон нутаг дах АМГТГ-ын хяналт тавих нөөц бололцоо дутмаг зэрэг шалтгаанууд нь ашигт малтмалын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Дээр дурдсанаар төрийн байгууллагууд чиг үүрэг давхардсанаас АМгХ-ийн хэрэгжилт, бодлого, хяналт нь орон нутгийн түвшинд нэгдсэн байдлаар хэрэгжиж чадахгүй байх үндэслэл болсон байна. Улсын төсвийн нэгээхэн хэсгийг бүрдүүлдэг чухал салбарын хувьд УУХҮЯ-ны бүтэц бүрэлдэхүүний асуудал, тэр дундаа орон нутагт салбар байгууллага ажиллуулах, мэргэшсэн хүний нөөцийг нэмэгдүүлэх гэм мэт асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

Засаг дарга тусгай зөвшөөрөл эзэмшигчийн уурхайн ашиглалт, нөхөн сэргээлтийн ажиллагаанд хяналт тавих, нөхөн сэргээлтийг хүлээн авах, барьцаа хөрөнгө байршуулахад болон буцаан олгох шийдвэрийг гаргах, хяналт тавих зэргээр

өргөн хүрээний чиг үүрэг хэрэгжүүлэхээр хуульд тусгагдсан байна. Дээрх байдлаар Засаг даргад хэт өргөн хүрээний чиг үүрэг олгосон нь тухайн салбарын мэргэжлийн байгууллагуудын чиг үүрэгтэй давхцах, Засаг даргын тамгын газрын зүгээс хяналт тавих ажилд мэргэжлийн боловсон хүчний дутагдалтай байдлаас хэлбэрийн төдийн хандах байдал ажиглагдаж байна.

Практикт Засаг даргад төлөвлөгөө, тайлан хүргүүлэх, батлуулах харилцаатай холбоотой тусгай зөвшөөрлийг цуцлах тохиолдол элбэг гардаг бөгөөд цаад шалтгаан нь субъектив шинжтэй, засаг дарга нь улс төрийн албан тушаал учраас асуудалд бодитой ханддаггүй байдлаас үүдсэн үр дагавар нийтлэг байна.

Энэ бүхийг дүгнэхэд, 1990 онд зах зээл, ардчилалд шилжих үеэс Уул уурхайн салбар орон нутагт салбар, нэгжгүй байснаас, орон нутаг, бүсийн нэгжийн үүргийг Засаг даргын тамгын газрын чиг үүрэгт хамааруулж хуульчилсан нь өнгөрсөн хугацаанд оновчтой зохицуулалт болж чадаагүй.

Иймд Аймаг, нийслэл дэх геологи, уул уурхайн асуудал хариуцсан нэгж нь дээр дурдсан олон хүндрэлтэй асуудлыг шийдэх боломжтой байна.

28 дугаар зүйл. Хайгуулын үйл ажиллагаа эрхлэх

28.1. Хайгуулын үйл ажиллагааг тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайд явуулна.

28.2. Энэ хуульд заасан тайлан, төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд холбогдох төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

28.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын тусгай зөвшөөрлийн эхний гурван жилийн хугацаанд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг хийлгэнэ.

28.4. Хайгуулын тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд ашигт малтмалын нөөцийг тогтоож, ордыг ашиглалтад оруулах бэлтгэл ажлын хүрээнд дараах баримт бичгийг боловсруулж, холбогдох төрийн байгууллагад энэ хуульд заасан хугацаанд хүргүүлнэ:

28.4.1. хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник, эдийн засгийн үндэслэл;

28.4.2. байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ;

28.4.3. уурхай, үйлдвэрийн хаалтын төлөвлөгөө;

28.4.4. хаалтын санхүүгийн баталгаа.

28.5. Ашигт малтмалын ордын нөөцийг энэ хуулийн 17.1.7-д заасан ангиллын дагуу тооцоолж, үнэлсэн байна.

28.6. Хайгуулын ажлын үр дүнгийн тайланг олон улсын стандартын дагуу гүйцэтгэж болно.

2006 оны АМТХ-д зааснаар ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосны дараа ТЭЗҮ, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННҮ), уурхайн хаалтын төлөвлөгөө хийгддэг. Мөн ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохдоо санхүүгийн баталгааг шаардахгүйгээр шууд олгож байгаа нь олон улсын тогтсон жишигтэй урвуу хамааралтай байна. Уурхайн хаалтын төлөвлөгөөг ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосны дараа уурхайг хаахаас 1 болон 3 жилийн өмнө боловсруулна гэж АМТХ болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зөрчилтэй байдлаар зохицуулж байсан. Мөн АМТХ-д тусгагдсан уурхайн хаалтын зохицуулалт нь уурхайн хаалтын төлөвлөгөөнд юуг тусгах нь тодорхойгүй, АТЗ олгосны дараа санхүүгийн баталгаа шаардахгүйгээр уурхайн хаалтын төлөвлөгөөг боловсруулж байсан нь нөхөн сэргээгдээгүй талбай ихээр бий болох нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал;

- 2016 оны байдлаар 15 аймгийн 56 сумын нутаг дэвсгэрт 566 нэгж талбарт 3984.46 га газар уул уурхайн улмаас эвдрэлд орж эзэнгүй орхигдсон байна. Эвдрэлд орж эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээхэд хамгийн багадаа 1 га талбайг 25.0 сая төгрөгөөр бүрэн нөхөн сэргээхэд 80-100 тэрбум төгрөгийн зардал шаардлагатай. 2016 оны байдлаар нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд 10.5 тэрбум төгрөгийг байршуулсан байгаа нь нийт шаардагдах хөрөнгийн 10 хувьтай тэнцэж байжээ.
- 2017 онд Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас хийсэн судалгаанд дурдсанаар уул уурхайн олборлолтын үйл ажиллагааны нөлөөгөөр улсын хэмжээнд 10084.29 га талбай сүйтгэгджээ. Үүнээс техникийн нөхөн сэргээлтийг 2600 орчим га талбайд хийсэн бол ердөө 53 га талбайд л биологийн нөхөн сэргээлт хийсэн байна. БОАЖЯ-наас нөхөн сэргээлт хийх шаардлагатай талбайн хөрөнгийг нийт 188 тэрбум төгрөг гэж тооцсон байна.
- 2019 оны эцсийн байдлаар 1,100 байршилд 27,405 га газар эвдэрснээс 8.8 мянган га газар буюу уул, ус, мод хамрах газар эзэн холбогдогч нь олдохгүй байгаа бөгөөд нөхөн сэргээхэд эхний ээлжид 540 тэрбум төгрөг шаардагдах тооцоог БОАЖЯ хийжээ³.

Дээрх хугацаанд төлөвлөсөн нөхөн сэргээлтийн ажлууд хийгдэж байгаа боловч эвдэрсэн нөхөн сэргээх шаардлагатай талбайн хэмжээ буурахгүй байгаа нь хариуцлагатай уул уурхайн хөгжүүлэх үйл хэрэгт бэрхшээл учруулж байна. Мөн дээрх байгаль орчинд учирсан хохирлын улмаас уул уурхайн ААН-ийн үйл ажиллагааг зогсоохыг шаардсан, тусгай зөвшөөрлийн цуцлахыг шаардсан хөдөлгөөн улс орон даяар өрнөсөн бөгөөд байгаль хамгаалах зорилго бүхий ТББ болон орон нутгийн иргэдийн эсэргүүцэл уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт татах чадварыг сулруулах хүчин зүйл болж байна.

Энэхүү хуулийн хийдлийг арилгаж төслийн 28.4-т ашиглалтын тусгай зөвшөөрлийг хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, ТЭЗҮ, БОННУ, уурхайн хаалтын төлөвлөгөө болон санхүүгийн баталгааны гэрчилгээ зэргийг ирүүлсний дараа олгохоор тусгасан нь одоогийн нөхөн сэргээгдээгүй талбай үүнээс үүдэлтэй орон нутгийн эсэргүүцэл зэрэг сөрөг үр дагавар үүсэхээс сэргийлэх чухал ач холбогдолтой зохицуулалт байна.

88 дугаар зүйл. Мэргэжлийн холбоо, мэргэшсэн мэргэжилтэн

88.1. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь аудитор, маркшейдер, хөрөнгийн үнэлгээ хийх мэргэшсэн мэргэжилтнийг баталгаажуулах, тэдгээрт эрх олгох, сунгах, цуцлах чиг үүргийг гэрээний үндсэн дээр мэргэжлийн холбоогоор гүйцэтгүүлж болно.

88.2. Мэргэжлийн холбоо нь нийтийн эрх зүйн хуулийн этгээд байх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна:

88.2.1. боловсрол, мэргэжлийн туршлага дээр үндэслэсэн гишүүнчлэлтэй байх;

88.2.2. мэргэжлийн стандартыг дагаж мөрддөг, байгууллагаас тогтоосон ёс зүйн дүрэм биелүүлэхийг шаарддаг байх;

88.2.3. мэргэжил, мэдлэгээ байнга дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлсэн байх;

³ <https://eic.mn>

88.2.4. гишүүнээс түдгэлзүүлэх, гишүүнчлэлээс хасах зэрэг сахилгын хариуцлага хүлээлгэх зохих эрх мэдэлтэй байх;

88.2.5. чиглэл, чиглэлийн асуудлыг хариуцсан бүтэцтэй байх;

88.2.6. гадаадын ижил төстэй төрийн бус байгууллагатай харилцаа, холбоо тогтоосон байх;

88.2.7. хуульд заасан бусад.

88.3. Мэргэжлийн холбоо, түүний гишүүнчлэл, үйл ажиллагаа нь олон нийтэд ил тод байна.

88.4. Мэргэжлийн холбоо нь энэ хуулийн 79.2-т заасан гэрээний хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

88.4.1. мэргэшсэн мэргэжилтний эрх олгох, үргэлжилсэн сургалт зохион байгуулах;

88.4.2. мэргэшсэн мэргэжилтэн, технологийн аудитор, хөрөнгийн үнэлгээчний ёс зүйн дүрмийг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

88.4.3. үндэсний стандарт боловсруулах, хэрэглээний тайлбар, аргачилсан зөвлөмж, гарын авлага боловсруулан гаргах;

88.4.4. хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагааг арга зүйн удирдлага, зөвлөгөө мэдээллээр хангах;

88.4.5. тухайн мэргэжлийн үйл ажиллагааны стандарт, мэргэжлийн ёс зүйн дүрмийг зөрчсөн мэргэшсэн мэргэжилтний эрхийг хүчингүй болгох.

88.5. Мэргэшсэн мэргэжилтэн нь геологи, уул уурхайн салбар, чиглэлийн мэргэжлээр дээд боловсролтой, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил тасралтгүй ажилласан, мэргэжлийн холбооны гишүүний шаардлага хангасан иргэн байна.

88.6. Мэргэшсэн мэргэжилтэн нь энэ хуульд заасан хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, уурхайн хаалтын төлөвлөгөө боловсруулах, тэдгээрт шинжээчийн дүгнэлт гаргах, маркшейдерийн хэмжилт зураглал, технологийн аудит, ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ хийх зэрэг мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлнэ.

Салбарын мэргэжлийн холбоодын оролцооны талаар Ашигт малтмалын тухай хуулийн 10.1.13-т “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд зөвлөмж гаргах, дэмжлэг үзүүлэх зорилго бүхий төрийн байгууллага, хөрөнгө оруулагч, мэргэжлийн холбоод болон төрийн бус байгууллагын төлөөллийн тэгш байдлыг хангасан орон тооны бус бодлогын зөвлөлийг байгуулж, бүрэлдэхүүн, түүний ажиллах журмыг батлах,” гэж, 10.1.16-д “геологи, уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журмыг батлах,” гэж тус тус заасан байна. Энэхүү заалтын хүрээнд мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг Уул уурхайн мэргэжлийн холбоодын дээд зөвлөл болон Монголын Геологийн холбоодын нэгдсэн зөвлөл зэрэг байгууллагууд хариуцан ажиллаж байна.

Хуулийн төслийн мэргэжлийн холбоо, мэргэшсэн мэргэжилтний бүтэц, үйл ажиллагааны чиглэлийн талаар 86 дугаар зүйл болгон шинээр оруулсан ба 88 дугаар зүйлд “Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь аудитор, маркшейдер, хөрөнгийн үнэлгээ хийх мэргэшсэн мэргэжилтнийг баталгаажуулах, тэдгээрт эрх олгох, сунгах, цуцлах чиг үүргийг гэрээний үндсэн дээр мэргэжлийн холбоогоор гүйцэтгүүлж болно” гэж заасан бөгөөд эдгээр мэргэжлийн холбоодын хийх ажлуудыг тодорхой тусгасан байна.

Дээр дурдсан зохицуулалтад хамаарах идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн холбоодод судалгаа хийхэд 40 орчим мэргэжлийн холбоо, зөвлөл, нийгэмлэг, ТББ, хүрээлэн байна. Үүнд:

1. Монголын геологийн холбоодын нэгдсэн зөвлөл

2. Монголын геологийн холбоо
3. Монголын геохимичдийн холбоо
4. Монголын Геофизикчдийн холбоо
5. Монгол Улсын Өрөмдлөгийн Холбоо
6. Монголын Гидрогеологичдийн Холбоо
7. Монголын геологи уул уурхайн салбарын ахмадын холбоо
8. Монголын уул уурхайн Геоэкологи холбоо
9. Монголын үйлдвэрлэлийн геофизикчдийн нийгэмлэг
10. “Ус хөгжлийн түлхүүр” гидрогеологийн холбоо
11. Дорнод монголын хайгуулчдын холбоо
12. Монголын өнгөт эрдэнийн чулууны мэргэжлийн холбоо
13. Монголын геологийн эмэгтэйчүүдийн холбоо
14. Төвийн геологийн “Хайгуулчин холбоо”
15. Монголын нүүрс судлаачдын хүрээлэн
16. “Эрдэнийн эрэлчид”-ийн холбоо
17. Монголын хайлуур жонш олборлон үйлдвэрлэгч, судлаачдын холбоо
18. Монголын хайгуулчин залуучуудын холбоо
19. “Дэлгэр мөрөн” Геологичдын холбоо
20. Монголын ус экологийн орчин холбоо
21. Геологи гидрогеологийн “Баян” холбоо
22. Үйлдвэрлэлийн геологийн холбоо
23. Монголын ашигт малтмал баяжуулагчдын холбоо
24. Монголын уул уурхайн зураг төсөл зохиогчдын холбоо
25. Монголын маркшейдерийн холбоо
26. Монголын ил уурхайн инженерүүдийн холбоо
27. Тэсэлгээний ажил үйлчилгээ, эрхлэгчдийн холбоо
28. Жонш олборлогч, үйлдвэрлэгч, экспортлогчдын холбоо
29. Монголын экспортлогчдын холбоо
30. Монголын эрдэс баялгийн эдийн засагч, менежментийн нийгэмлэг
31. Ашигт малтмалыг ил аргаар олборлогч инженерүүдийн холбоо
32. Уул уурхайн тогтвортой хөгжлийг дэмжих хүрээлэн
33. Монголын уул уурхайн үйлдвэрийн цахилгаан, механикчдын холбоо
34. Монголын химич, химийн инженерүүдийн нэгдсэн холбоо
35. Монголын далд уурхайн инженерүүдийн холбоо
36. ШУТИС-ийн ГУУСургууль
37. ШУТИС-ийн ГУУС-ийн Уул уурхайн хүрээлэн
38. Нүүрс ассоциаци ТББ

Иймд хуулийн төслийн энэхүү зохицуулалт нь одоогийн байдлаар тодорхой хэмжээнд хэрэгжиж байгаа, энэхүү зохицуулалтыг хэрэгжүүлэх төрийн бус байгууллагын нөөц хангалттай байгаа тул практикт хэрэгжих боломжтой байна.

50 дугаар зүйл. Улсын зохицуулалттай уурхай

50.1. Улсын зохицуулалттай уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон түүний туслан гүйцэтгэгч нь Монгол Улсын иргэдийг ажлын байраар хангах үүрэг хүлээх бөгөөд тухайн хуулийн этгээдийн ажилтны 10-аас дээшгүй хувь нь мэргэжлийн өндөр ур чадвар шаардах ажил, мэргэжлээр ажиллах гадаадын иргэн байж болно.

50.2. Улсын зохицуулалттай уурхай нь гадаадын иргэдийг энэ хуулийн 50.1-д зааснаас илүү

хэмжээгээр авч ажиллуулсан тохиолдолд ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг сар бүр төлнө.

50.3.Энэ хуулийн 50.2-т заасан төлбөрийг тухайн сум, дүүргийн төсөвт төвлөрүүлж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих болон боловсрол, эрүүл мэндийн салбарт зарцуулах бөгөөд энэ талаарх журмыг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

50.4.Улсын зохицуулалттай уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь орон нутагтай хамтран ажиллах гэрээг энэ хуулийн 14.1.5-д заасан журмын дагуу аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулна.

51 дүгээр зүйл.Орон нутгийн зохицуулалттай уурхай

51.1.Энэ хуулийн 8.2-т заасан уурхай нь орон нутгийн зохицуулалттай уурхайд хамаарна.

51.2.Орон нутгийн зохицуулалттай уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь орон нутагтай хамтран ажиллах гэрээг энэ хуулийн 14.1.5-д заасан журмын дагуу сум, дүүргийн Засаг даргатай байгуулна.

51.3.Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 51.2-т заасан гэрээний төслийг тухайн уурхайн үйл ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй орон нутгийн оршин суугчдад танилцуулна.

66 дугаар зүйл.Хайгуулын үйл ажиллагааны үед орон нутагтай харилцах

66.1.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь орон нутагтай хамтран ажиллах гэрээг тухайн сум, дүүргийн Засаг даргатай дараах чиглэлийн хүрээнд байгуулж болно:

66.1.1.иргэдийг ажлын байраар хангах;

66.1.2.орон нутгийн хангаан нийлүүлэгчдийг худалдан авалтаар дэмжих.

66.2.Сум, дүүргийн Засаг дарга орон нутагтай хамтран ажиллах гэрээний төсөлд тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэдээс санал авна.

66.3.Аливаа этгээд тусгай зөвшөөрөл эзэмшигчээс орон нутагтай хамтран ажиллах гэрээнд зааснаас бусад зүйл шаардахыг хориглоно.

67 дугаар зүйл.Ашиглалтын үйл ажиллагааны үед орон нутагтай харилцах

67.1.Улсын зохицуулалттай уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд орон нутагтай хамтран ажиллах гэрээг аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулж болно.

67.2.Орон нутгийн зохицуулалттай уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь сум, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд орон нутагтай хамтран ажиллах гэрээг сум, дүүргийн Засаг даргатай байгуулна.

67.3.Аливаа этгээд тусгай зөвшөөрөл эзэмшигчээс орон нутагтай хамтран ажиллах гэрээнд зааснаас бусад зүйл шаардахыг хориглоно.

68 дугаар зүйл.Баяжуулалтын үйл ажиллагааны үед орон нутагтай харилцах

68.1.Баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь сум, орон нутгийн хөгжлийн таван жилийн үндсэн чиглэлийн хүрээнд орон нутагтай хамтран ажиллах гэрээг тухайн аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулна.

68.2.Сум, дүүргийн Засаг дарга орон нутагтай хамтран ажиллах гэрээний төсөлд тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэдээс санал авна.

68.3.Аливаа этгээд тусгай зөвшөөрөл эзэмшигчээс орон нутагтай хамтран ажиллах гэрээнд зааснаас бусад зүйл шаардахыг хориглоно.

2020 онд 17 аймагт олборлолтын үйл ажиллагаа явуулсан тухай үйл ажиллагааны 142 тайланг баталгаажуулсан байна. Үүнээс “Ашигт малтмалын тухай хууль”-ийн 42.1-д зааснаар ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нутгийн захиргааны байгууллагатай “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх гэрээ” ирүүлсэн 76, гэрээ ирүүлээгүй болон байгуулаагүй 66 аж ахуйн нэгж байна.

Гэрээнд орон нутагт хөрөнгө оруулахаар 33,7 тэрбум.төгрөг, орон нутгаас худалдан авалт хийхэд 14,8 тэрбум төгрөг тус тус зарцуулснаар тусгасан байна. /Зарим гэрээнд мөнгөн дүн тусгагдаагүй байдаг тул нийт гэрээний дүн гэж үзэхэд учир дутагдалтай./ Орон нутгаас нийт 659 ажиллагсдыг ажлын байраар хангасан гэж тайлагнасан байна.

№	Аймаг	Гэрээ байгуулсан	Орон нутгийн хөгжилд зарцуулсан /сая.төг/	Орон нутгаас худалдан авалт хийсэн мөнгөн дүн /сая.төг/	Орон нутгаас ажиллагсдын тоо
1	Баянхонгор	5	484,4	100,3	66
2	Булган	9	396,4	-	42
3	Говь-Алтай	2	4	-	-
4	Дархан-Уул	3	369,5	1597	47
5	Дорноговь	4	44,2	-	-
6	Дорнод	4	491,9	2736	246
7	Дундговь	7	163,2	-	12
8	Завхан	1	78,5	-	81
9	Орхон	2	14585	10300	-
10	Өвөрхангай	3	98	-	-
11	Өмнөговь	1	14762	-	-
12	Сүхбаатар	3	1639,5	-	-
13	Сэлэнгэ	8	302,8	64,6	49
14	Төв	17	230,4	50	106
15	Увс	1	-	-	-
16	Ховд	1	-	-	-
17	Хэнтий	6	49	17,5	16
Нийт		76	33698,7	14865,4	659

Өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Ашигт малтмалын тухай хуулийн 42.1-д гэрээ байгуулахыг аж ахуй нэгжид даалгаснаас үүдэн орон нутгийн удирдлага гэрээ байгуулахгүй эсэргүүцэх, үүнээс болж үйл ажиллагаа явуулахгүй зогсоох зэрэг асуудлууд үүссээр байна. Мөн Ашигт малтмалын тухай хуулийн 42.1-д заасан гэрээг аймаг эсхүл сумын аль түвшинтэй байгуулах харилцааг нарийвчлан тодорхойлоогүйгээс зарим нэг уурхайн хувьд аймаг болон сумтай тус бүр гэрээ байгуулах тохиолдол гарч байна. Иймд тус хуулийн төсөлд орон нутагтай хамтран ажиллах гэрээг орон нутгийн зохицуулалттай уурхайн хувьд орон нутагтай хамтран ажиллах гэрээг сум, дүүргийн Засаг даргатай, улсын зохицуулалттай уурхайн хувьд орон нутагтай хамтран ажиллах гэрээг аймаг, нийслэлийн Засаг даргатай

байгуулахаар заасан нь дээр дурдсан хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх шийдэл болсон байна.

Мөн орон нутагтай хамтран ажиллах гэрээ байгуулахад уул уурхайн компаниудаас хульд заагаагүй зүйл шаардах, хандив тусламж гуйх зэргээр хүндрэл учруулах нь элбэг тул тус төслийн 67.1-д “Улсын зохицуулалттай уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд орон нутагтай хамтран ажиллах гэрээ байгуулах”, 66.1-д “Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь орон нутагтай хамтран ажиллах гэрээг тухайн сум, дүүргийн Засаг даргатай иргэдийг ажлын байраар хангах, орон нутгийн ханган нийлүүлэгчдийг худалдан авалтаар дэмжих чиглэлээр байгуулах”, 68.3-т “аливаа этгээд тусгай зөвшөөрөл эзэмшигчээс орон нутагтай хамтран ажиллах гэрээнд зааснаас бусад зүйл шаардахыг хориглоно” гэж тус тус заасан нь хамтран ажиллах гэрээний зориулалт, хүрээ хязгаарыг ойлгомжтой байдлаар зохицуулсан нь энэхүү гэрээг байгуулахтай холбоотой үүсэж буй хүндрэлийг арилгахад чиглэсэн зохицуулалт болсон байна.

73 дугаар зүйл. Технологийн аудит

73.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь техник, технологийн ашиглалтыг сайжруулах, зардлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор технологийн аудит хийлгэж болно.

73.2. Технологийн аудитыг дараах тохиолдолд заавал хийлгэнэ:

73.2.1. ашиглах, баяжуулах технологи өөрчлөгдөх;

73.2.2. ашиглах, баяжуулах технологийн горимын хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх зорилгоор геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага шаардсан;

73.2.3. ашиглах, баяжуулах үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөний улмаас үйлдвэрлэлийн осол гарсан;

73.2.4. баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч үйл ажиллагаа эхлүүлэхээс өмнө.

73.3. Ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь технологийн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

73.4. Ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь технологийн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг тухайн жилийн ашиглалтын эсхүл баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны тайланд хавсаргаж ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

73.5. Технологийн аудитыг 17.1.21-д заасан журмын дагуу эрх авсан аудитор хийнэ.

73.6. Технологийн аудитын эрх олгох, сунгах, түдгэлзүүлэх, цуцлах журам, технологийн аудит хийх аргачлалыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

73.7. Төрийн аудитын байгууллагаас захиргааны байгууллагын үйл ажиллагаанд аудит хийхтэй холбогдсон харилцаанд энэ зүйл хамаарахгүй.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 242 аж ахуйн нэгж 2020 онд үйл ажиллагаа явуулж уулын ажлын тайлан ирүүлсэн байна. Эдгээр уурхайнуудыг ашиглалтын технологиор нь авч үзвэл 19 далд, 211 ил, хосолсон технологитой 12 уурхай тус тус байна.

Ашигт малтмалын	Далд	Ил	Хосолсон	НИЙТ
-----------------	------	----	----------	------

төрөл				
Алт (Үндсэн)	3	7		10
Алт (Үүсмэл)		5		5

**Ашиглалтын технологи
/уулын ажлын тайлан/**



Ашигт малтмалын төрлөөр нь авч үзвэл алтны үндсэн ордын 10, алтны шороон ордын 99, нүүрсний 55, шохойн чулууны 15, төмрийн хүдрийн 14, хайлуур жоншны 30, бусад ашигт малтмалын 19 уурхай тус тус тайлан ирүүлсэн байна.

Нийт тоног төхөөрөмжүүдийг насжилтын хувьд авч үзвэл дунджаар 6 жил ашиглагдаж байна. Уурхайн хөдөлмөрийн аюулгүй байдалд тухайн техникийн бэлэн байдал,

насжилт, аюулгүй ажиллагаа чухал ач холбогдолтой.

Тус хуулийн төслийн 73-р зүйлд “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь техник, технологийн ашиглалтыг сайжруулах, зардлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор технологийн аудит хийлгэж болно” гэж заасан нь төрийн байгууллагаас бус, хөндлөнгийн аудитыг, мэргэжлийн тусгай зөвшөөрөл бүхий этгээдээр гүйцэтгүүлэхээр заасан нь төрийн хяналтын ачааллыг бууруулсан, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангахад ач холбогдол бүхий зохицуулалт болсон байна.

4.3 “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 26, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан хангасан эсэхэд хариулт өгөх замаар төслийг бүхэлд нь шалгалаа.

Мөн хуулийн төсөлд холбогдох байгууллагуудаас ойлгомжтой болгох чиглэлээр ирүүлсэн санал байгаа эсэхийг нягтлан, дүн шинжилгээ хийсэн болно.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд зааснаар хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлбэрээр бичигдсэн 19 бүлэг, 97 зүйлтэй, хуулийн төслийн бүтцийн дугаарлалт хуульд заасан шаардлагыг хангасан байна.

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хуулийн бүтэц, хэлбэрт нийцсэн байна.

Хуулийн төсөлд холбогдох мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээдээс ирүүлсэн саналд шүүлт хийж үзвэл төслийн бичвэрийн томъёоллын ойлгомжтой байдлын шаардлагад нийцсэн байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага		
Дд	Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
1	29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцсэн байна.
2	29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Тус хуулийн төслөөр ашигт малтмалыг эрэх үйл ажиллагаанаас эхлэн уурхайг хаах, хаалтын дараах үйл ажиллагаанд хамаарах бүхий л асуудлыг бүрэн тусгасан.
3	29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Хуулийн төсөлд тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгаагүй.
4	29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Тус хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгаагүй.
5	29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Төслийн зүйл, хэсэг, заалт хоорондоо зөрчилдөөгүй байна.
6	29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Нэг удаа хэрэгжүүлэх заалт хуулийн төсөлдөө тусгаагүй.
7	29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Бусад хуулийн заалтыг давхардуулан заагаагүй.
8	29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн	Тус хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд

	харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журамд нийцсэн.
9	29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн төрийн албан хаагч, эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацааны зохицуулалтыг тусгасан.
10	29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай, Ашигт малтмалын тухай хуулийг тус тус хүчингүй болгох тухай болон Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулсан.
30 дугаар зүйл. Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага		
1	30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэсэн.
2	30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлээгүй.
3	30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Тус шаардлагад нийцсэн байна.
4	30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Хүч оруулсан нэр томъёо хэрэглээгүй.
5	30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Тус шаардлагад нийцсэн байна.

4.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

“Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын 4.10-т заасан уялдаа холбоог шалгах хэрэгсэлд дурдагдсан шалгуурыг хангасан эсэхийг дараах байдлаар үнэллээ. “Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

д/д	Асуулт	Хариулт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	тийм	Хуулийн төслийн зохицуулалт нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг бүрэн хангаж байна.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх.	тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	тийм	Зарчмын зөрүүтэй ямар нэгэн асуудал дүн шинжилгээний хүрээнд илрээгүй болно.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Тийм	Хуулийн төслийг хэрэгжүүлэгч субъектүүдийн эрхүүргийг ялган тодорхойлсон байна.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	үгүй	Хуулийн төсөлд байх бүхий л зохицуулалтыг тусгасан.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх.	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Тийм	Төрийн байгууллагын зарим чиг үүргийг “мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага”-аар гүйцэтгүүлэхээр зохицуулах

			боломжтой.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх.	Үгүй
11	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх,	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
12	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	-	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой.
13	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх		Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Өрсөлдөөний тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой.
14	Хуулийн төсөлд авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	үгүй	Хяналтаар энэ төрлийн зөрчил илрээгүй.
15	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх		Тухайн хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хууль, Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хуульд тусгасан.

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖӨГӨХ

1.ҮР ДҮНГ БАРИМТЖУУЛАХ

Ашигт малтмалын тухай шинэчилсэн найруулгын хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд зориулж шалгах хэрэгслийг хэрэглэх явцад ашигласан мэдээлэл тоо баримт, дүгнэлт, оролцогчид, мэргэжлийн холбоодын санал зэрэг холбогдох бүх материалыг цуглуулсан бөгөөд хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх үе шат бүрийг баримтжуулаа. Энэ нь хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааны үр дүнг дүгнэж, зөвлөмж өгөх үндэслэл болох бөгөөд цуглуулсан бүх баримт, мэдээлэл зөвлөмжийн хавсралт⁴ болно.

2.ҮНЭЛЭХ

Хуулийн төслийн үр нөлөөг Зорилгод хүрэх байдал, Практикт хэрэгжих боломж, Уялдаа холбоо, Зардал тооцох гэсэн шалгууруудаар ерөнхийд нь үнэлэхэд Хууль тогтоомжийн тухай хуулийн хуулийн төсөлд тавигдах шаардлагыг хангасан гэж дүгнэхээр байна. Үүнийг шалгуур тус бүрээр нарийвчлан авч үзвэл

№	Шалгуур	Дүгнэлт
1.	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн сонгогдсон зохицуулалт нь хуулийн төслийн зорилго болон түүнийг боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад нийцэж байна.
2.	Практикт хэрэгжих боломж	Ил тод байдлын зөвлөл, түүний ажлын алба нь Засгийн газрын тогтоолоор байгууллагад олон улсын байгууллагаас санхүүжиж ажиллаад нэлээдгүй удсан нь практикт хэрэгжүүлэх боломжтойг илэрхийлж байна. Гэхдээ хуулийн төслийн анхан шатны тайлан гаргах цаг хугацаа, тайлан нэгтгэх, тайланг мэдээлэх зэрэг цаг хугацааны хувьд хэрэгжих боломжтой эсэхийг анхаарах шаардлагатай байна. Үндэсний зөвлөлийн гишүүнээр оролцох хуулийн этгээд, иргэний нийгмийн төлөөллийг олон нийтэд ил тод зарлах, төлөөллийг нээлттэй сонгон шалгаруулах журам батлах эрхийг хуулийн төсөлд журамлан зохицуулаагүй байгаа нь процедурын тодорхойгүй байдал үүсгэх эрсдэл үүсгэж мэдэхээр байх тул тус журмыг батлах эрхийг Үндэсний зөвлөл эсхүл өөр тохирох этгээдэд олгох нь зүйтэй байна.

⁴ Баримтжуулсан материалуудыг хавсралт хэсгээс харна уу.

3.	Ойлгомжтой байдал	<p>Хуулийн төслийн “3.2.Энэ хууль нь эрдэс баялгийн салбарын мэдээллийн санд түшиглэн эрдэс баялгийн салбарын бодлого, төлөвлөлтийг сайжруулах, орлого, үр өгөөж, эдийн засгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хэрэгжүүлэх арга хэмжээний зарчмыг тодорхойлох, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх болон эрдэс баялгийн салбарын үйл ажиллагаанд оролцогчдын чиг үүрэг, эрх зүйн байдалтай холбогдсон харилцаанд хамаарна.” гэж заасан нь хуулийн төслийн зорилт болон зохицуулалтаас хальсан байна.</p> <p>Хуулийн төсөлд “тогтмол мэдээлнэ” гэж 26 удаа орсон боловч үүнийгээ нэр томъёоны тодорхойлолтод тусгаж өгөөгүйн улмаас төөрөгдөл үүсгэх боломжтой байна.</p> <p>Хуулийн төслийн 9.1.3-т “байгууллагууд”, 23.2.1, 24.6-д “гишүүдийн” 24.4.2-д “тайлангууд гэсэн үгийг олон тоон дээр хэрэглэсэн байгааг тус тус засах шаардлагатай.</p>
5.	Уялдаа холбоо	<p>Хуулийн төсөлд бусад хуультай уялдуулах зарим зохицуулалт байна. Үүнд:</p> <p>Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн уул уурхайн холбогдох тайлан гаргах зохицуулалтууд</p> <p>Татварын ерөнхий хуулийн 4.1-д зааснаар татварыг зөвхөн Улсын Их Хурал татварын хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй. Харин тус төслийн 11-р бүлэгт Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн зохицуулалтыг тусгасан байгаа нь Татварын ерөнхий хуультай нийцэхгүй байгаа нь “Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон” эсэх гэсэн “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэхаргачлал”-ын 4.10-т заасан шалгуур үзүүлэлтэд нийцэхгүй байгааг анхаарч тус шалгуурт нийцүүлэхийг зөвлөж байна.</p>

3.3ӨВЛӨМЖ ӨГӨХ

Хуулийн төслийн бүтэц зохицуулах харилцаа, хамрах хүрээ, агуулгыг дүн шинжилгээг Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу хийв.

Шинэчлэн найруулсан Ашигт малтмалын тухай хуулийн төсөл нь олон улсын тогтвортой хөгжлийн сайн туршлагыг нэвтрүүлэх, хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн шалгуур, шаардлагыг тодорхой болгон хяналтын болон салбарын удирдлагын тогтолцоог бий болгох, байгаль орчныг хамгаалах, олон нийтийн оролцооны зохицуулалтыг оновчтой болгох, бусад хуультай давхардсан болон зөрчилдсөн зохицуулалтууд, түүнчлэн зохицуулагдаагүй байсан хийдэл бүхий харилцаануудыг зохицуулах зорилгоор тодорхой зохицуулалтуудыг тусган боловсруулжээ.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлээд дараах зөвлөмжийг гаргаж байна. Хуулийн төслийн уялдааг хангах үүднээс Уялдаа холбоо хэсэгт дурдагдсан Татварын ерөнхий хуультай зөрчилдсөн зохицуулалтуудыг нийцүүлэх шаардлагатай байна.

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨГӨХ САНАЛ ШҮҮМЖ БОЛОВСРУУЛАХ
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТЭМДЭГЛЭЛ